



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/298

Хэрлэн сум

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалын 2 дахь заалт, уг тушаалаар батлагдсан "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2.3, 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийн 6.4, 6.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, тайлагнах үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	-Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	-Боловсрол, соёл, урлагийн газрын дарга
Гишүүд:	-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	-Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дарга
	-Боловсрол, соёл, урлагийн газрын эх хэлний судлагдахуун хариуцсан мэргэжилтэн
	-Хэрлэн лаборатори I дүгээр сургуулийн захирал
	-Хэрлэн V дугаар цэцэрлэгийн эрхлэгч
	-Хэрлэн I дүгээр сургуулийн багш
	-Хэрлэн IV дүгээр сургуулийн эцэг эхийн зөвлөлийн дарга

2//.

2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавихдаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль, тогтоомж болон тус журмын хүрээнд үйл ажиллагаа явуулан, ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны зардлыг үр ашигтай зарцуулахыг зөвлөлийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс / Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА